

ХАНБОГД СУМЫН МАЛЧИДАД ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТАЛБАЙГААС ТҮР ХУГАЦААГААР УС ЗӨӨВӨРЛӨН ХҮРГЭХ ЖУРАМ

ЗОРИЛГО

Энэхүү журмыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Оюу толгой ХХК-ны уурхайн талбай орчимд нутагладаг малчдад усны хомсдол үүссэн үед зөөврийн усаар түр хангах ажлыг зохион байгуулахад баримтлана.

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Малчдад ус зөөвөрлөн хүргэх ажлыг зохион байгуулах болон талуудын үүрэг, харилцааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2 Оюу толгой ХХК нь уурхайн талбайгаас 20 км-н тойрог дотор нутагладаг малчдын худгийн усны нөөц муудсан үед уурхайн талбайгаас мал услах зориулалттай ус (ундны ус биш) зөөвөрлөн хүргэх ажлыг хариуцан зохион байгуулна.
- 1.3 Зөөврийн ус малчдад хүргэх шийдвэрийг малчны хүсэлт, сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтний санал, Багийн даргын тодорхойлолт зэргийг үндэслэн гаргана.
- 1.4 Ус зөөвөрлөх шийдвэрийг үндэслэн оролцогч талууд түр хугацааны санамж бичиг үйлдэх ба санамж бичигт хэдий хэмжээний ус, ямар давтамжтайгаар ямар хугацаатай зөөхийг тогтоож тусгасан байна.

ХОЁР. Талуудын үүрэг

- 2.1 Шаардлагатай үед орчны өвөлжөө, хаваржаатай малчин өрхүүдээс зөвшөөрөл авсан тохиолдолд зунжааны нутагт ус зөөвөрлөн хүргэх ажлыг хийж болно.
- 2.2 Худгийн усны нөөц нь муудсан малчин Оюу толгой ХХК-ны Бүсийн хөгжил, Нийгмийн хэлтэст зөөврийн ус хүргүүлэх хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд хэдэн айлын, хэдэн тооны мал услах болон ямар хугацаанд ус хүргүүлэх хэрэгцээ шаардлага байгааг тодорхой тусгасан байна.
- 2.3 Хүсэлт гаргаж буй малчин нь ойролцоо нутагладаг болон бэлчээр хамтран ашигладаг бусад малчиддаа энэхүү нөхцөл байдлаа танилцуулан, дэмжсэн бичиг үйлдүүлэн, гарын үсгээр баталгаажуулсан байна.
- 2.4 Багийн дарга нь тухайн малчны хүсэлтийг судлан үзэж нөхцөл байдлыг баталгаажуулсан тодорхойлолт гаргана.
- 2.5 Худгийн усны нөхцөл муудсан талаар малчин Багийн засаг даргад хүсэлт гаргаж энэ талаар сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнээс санал авсан байна.
- 2.6 Ус зөөвөрлөн хүргүүлэх малчны хүсэлтийг Оюу толгой ХХК нь хянан үзэж Багийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр ажлын 7-10 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 2.7 Оюу толгой ХХК нь санамж бичигт тусгасны дагуу тохирсон хэмжээний усыг тогтсон хугацаанд цаг алдалгүй зөөвөрлөн хүргэнэ.
- 2.8 Зөөврийн ус ашиглаж буй малчин нь Оюу толгой ХХК-с хангасан ус нөөцлөх сав бусад хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах ба санамж бичигт заасан хугацаа дуусахад хүлээлгэн өгнө.

2.9 Малчин өрхүүд ус нөөцлөх савыг өөрсдийн боломжоор бэлтгэх хүчин чармайлт гаргах бөгөөд энэ асуудлыг талууд харилцан тохиролцож шийднэ.

2.10 Энэхүү журмыг дагаж мөрдөхөд талууд идэвхи санаачлагатай байж, харилцан хяналт тавих үүрэг хүлээнэ.

ГУРАВ. Бусад

3.1 Энэхүү журам нь 2015 оны 3 сарын 20-ний өдрийн Ханбогд сумын орон нутгийн удирдлага, Малчдын төлөөлөл, Оюу толгой ХХК-ийн төлөөлөл оролцсон уулзалт хэлэлцүүлгийн үеэр харилцан тохиролцсоны дагуу энэ өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Ханбогд сумын орон нутгийн удирдлага, Малчдын төлөөлөл, Оюу толгой ХХК